



137

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 348

Улаанбаатар хот

Г Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган
нийлүүлэх байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн
хяналт, үнэлгээний мөрөөр авах арга хэмжээний тухай

Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 19.10 заалт, “Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих нийтлэг шаардлага” MNS5530:2009 стандарт, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын шийдвэр, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт үнэлгээний дүнг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй Эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез, биологийн идэвхит бүтээгдэхүүн ханган нийлүүлэх, импортлох, худалдах, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт үнэлгээний дүнгээр стандартын шаардлагын 70-аас доош хувийг хангаж байгаа буюу хангалтгүй үнэлгээ үзүүлсэн 13 байгууллагын тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
2. Тусгай зөвшөөрөл авсан чиг үүргийн дагуу болон албан ёсны хаяг дээрээ үйл ажиллагаа явуулаагүй, тодорхой ажлын байргүй зэрэг зөрчилтэй 17 байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
3. Тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлэх байгууллагын нэрийг нэгдүгээр, хүчингүй болгох байгууллагын нэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
4. Эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез, биологийн идэвхит бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ханган нийлүүлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт үнэлгээний явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, “Эм эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавих нийтлэг шаардлага” MNS5530:2009 стандартыг мөрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Я.Буянжаргал/-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /А.Эрдэнэтуяа/-д даалгасугай.

САЙД

Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 09 дугаар сарын 23-ны
өдрийн 348 дүгээр тушаалын
1 дүгээр хавсралт

158



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН НЭР

1. Азиател ХХК - Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, биологийн идэвхит бүтээгдэхүүн ханган нийлүүлэх, импортлох, худалдах
2. Илдэнгүн хошуу ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, ахуйн шавж мэрэгч устгах, ариутгах, халдвартгүйжүүлэх бодис ханган нийлүүлэх, импортлох, худалдах
3. Лабтех ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох, худалдах
4. Лидэрпрайм ХХК- Эм ханган нийлүүлэх, импортлох
5. Магос ХХК- Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох, худалдах
6. Маргад-Онъс ХХК- Эм, эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох
7. Мед монгол. ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох, худалдах
8. Перфект ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох
9. Си Ай Ти ХХК- Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох
- 10.Хаадын жор ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох
- 11.Хатагтай ХХК- Эмнэлгийн хэрэгсэл /шүдний / ханган нийлүүлэх, импортлох
- 12.Эдендент ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл /шүдний / ханган нийлүүлэх, импортлох
- 13.Эм Эс Ай Си Си ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл /жирэмснээс хамгаалах/ ханган нийлүүлэх, импортлох

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 09 дугаар сарын 23-ны
өдрийн 348 дүгээр тушаалын
2 дугаар хавсралт

139

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР

1. Антиб ХХК- Эм ханган нийлүүлэх, импортлох
2. Белладонна ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох
3. Болормөрөн ХХК- Эм ханган нийлүүлэх, импортлох
4. Дентафарм ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох
5. Дэгдфарм ХХК- Эм ханган нийлүүлэх, импортлох
6. Жамомед ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох
7. Интерфарм трейд ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох
8. Кумданг-Энх ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох
9. Мон Од бадрал ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох
10. Оол эм ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох
11. Санчир ундрах ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох
12. Содимпекс ХХК- Эм ханган нийлүүлэх, импортлох
13. Ти Си Эн ХХК- Эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох
14. Тимусфарм ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох
15. Царамхайрхан ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох
16. Эрдэнэбүрэн ХХК- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох
17. ЭМЖК ХХК- Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох